

МОНГОЛЫН ӨДӨР ТУТМЫН СОНИНУУДЫН  
ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТӨЛӨВШЛИЙН АСУУДАЛД

Б.Тогтохбаяр\*

\* МУИС-ийн Сэтгүүл зүйн тэнхмийн докторант, сэтгүүл зүйн магистр

**Түлхүүр үг:** өдөр тутмын сонин, Монголын анхны өдөр тутмын сонин, сонины зах зээл дэх өдөр тутмын сонинуудын эзлэх байр суурь, нийтлэлийн бодлого, төлөвшил.

**С**оёлт хүний өглөө өдөр тутмын сонины шинэ дугаар уншихаас эхэлдэг гэдэг. Италийн Венеци хотод анх “Газетта” хэмээх нэртэй янз бүрийн мэдээлэл агуулсан гар бичмэл хуудас гарч эхэлснээр сонин үүсч цаашдаа өдөр тутмын шинэ соргог мэдээллээр уншигчдыг хангадаг ОНМХ-ийн онцгой нэгэн төрөл болон хөгжсөн түүхтэй.

Монголын тогтмол хэвлэлийн түүхэнд тэрхүү соёлт хүний хэрэглээ болсон өдөр тутмын сонин 1961 онд үүсэн бий болсон гэж судлаачид үздэг. Тэр нь анх 1920 онд Эрхүүд хэвлэгдэн гарснаасаа 41 жилийн дараа өдөр тутмын сонин болж төлөвшсөн түүхтэй “Үнэн” сонин юм. “Үнэн” сонины хувьд захиалга борлуулалт нь огцом буурс-

наас 1990-ээд оны эхнээс гурав хоногт нэг дугаар гаргаж байснаа 2000 оны 10-р сараас эхлэн дахин өдөр тутмын сонины ангилалд багтах болсон онцлогтой.

Тэгэхээр Монголын өдөр тутмын сонин 45 жилийн түүхтэй бөгөөд тоо нь тасралтгүй нэмэгдсээр энэ онд тоо нь аравт хүрээд байна.

Монголын өдөр тутмын сонингийн үүсэл хөгжлийг түүхийн хувьд нь

- 1990 оноос өмнөх (“Үнэн”),

- Төр, засгийн төв хэвлэл (“Ардын эрх”, “Засгийн газрын мэдээ”, “Улаанбаатар”),

- Хувийн өмчид тулгуурласан үндэсний чөлөөт сонинууд (“Өнөөдөр”, “Монголын мэдээ”, шинэ “Ардын эрх”, “Өнөөдрийн Монгол”, “Нийгмийн толь”, “Өглөөний сонин”),

- Төр засгийн төв хэвлэлийн суурин дээр үүссэн чөлөөт өдөр тутмын сонин (“Өдрийн сонин”, “Зууны мэдээ”) хэмээн ангилж болох юм.

1990 оноос өмнөх үе буюу Монголын хувьсгалт хэвлэл үүсч хөгжсөн 70

жилийн түүхэнд анхны өдөр тутмын сонин "Үнэн" нь МАХН, төрийн шууд мэдэлд харьяалагдаж байсан бол эрх баригч намаас хараат бус төрийн төв хэвлэл "Ардын эрх" сонин үүссэнээр тогтмол хэвлэлийн түүхэнд шинэ хуудас нээсэн билээ. Түүгээр барахгүй "Ардын эрх" сонин нь нийтлэлийн бодлого, сэтгүүлчдийн бичлэгийн ур чадвар, ОНМХ-ийн нийгэмд гүйцэтгэдэг үндсэн үүрэг болсон мэдээлэх үүргээ тэргүүнд тавьсан шинэ үеийн анхны өдөр тутмын сонин загвар болон хөгжсөнөөрөө онцлог юм. Дараа нь Засгийн газрын төв хэвлэл "Засгийн газрын мэдээ" сонин, нийслэлийн Засаг захиргааны төв хэвлэл "Улаанбаатар" зэрэг төр, засгийн харьяалалтай өдөр тутмын сонинууд бий болж хөгжсөн түүхтэй.

Харин төрийн төв хэвлэл "Ардын эрх"-ээс анхны үндэсний чөлөөт өдөр тутмын сонин "Өнөөдөр" 1996 онд өрх тусгаарласан нь чөлөөт хэвлэлийн хөгжилд бас нэгэн томоохон реформ хийснээрээ асар их ач холбогдолтой юм. 1996 оны 9 дүгээр сарын 24 анхны дугаараа гаргахдаа:

"Хоёр сая гаруйхан хүнтэй гэхэд манай оронд хэдэн зуун сонин гарч байгаа ч нэлээд нь эсвэл улс төр, үзэл бодлын нэг талын хамааралд багтсан, эсвэл хувийн тодорхой зорилгод автаж задгайрсан хоёр туйлшралд холбирч буй нь хүмүүст сонирхлын тодорхой буюу өрөөсгөл төсөөллийг өгч байна. Энэ байдлаас ангижран улс төр, эдийн засаг, нийгэм оюун соёлын болон иргэний

хүрээний аливаа асуудлаар өргөн олон уншигчдадаа зөв мэдээлэл өгөх зорилгоор аль нэг нам, улс төрийн хүчний эрхшээлд үл автан бие даасан байх, аливаа туйлшралаас ангид, үнэн бодитой мэдээллээр уншигчдыг хангах зарчмыг иш болгон үндэсний хэмжээний чөлөөт сонин гаргахаар бид сэтгэл шулуудсан юм" хэмээн редакцийн зурвасаараа зорилго, нийтлэлийн бодлогоо тодорхойлж, Монголын сонин хэвлэлийн зах зээлд "шар" гэгддэг долоо арав хоног тутмын сонинууд л өөрсдийгөө үндэсний чөлөөт гэж тодорхойлдог, харин нийгмийн хамгийн оюунлаг хэсгийн хэрэглээ болсон, илүү сэтгүүл зүйн мэргэжлийн түвшинд мэдээллээ бэлтгэдэг, илүү буурьтай өдөр тутмын сонинууд нь том нам, төр, эсвэл бүр гүйцэтгэх засаглалын шууд харьяалалд ажилладаг байх үед жинхэнэ хараат бус үндэсний чөлөөт гэсэн статустай "Өнөөдөр" сонин гарч эхэлсэн нь нийгэмд шинэ үзэгдэл, олон ургальч үзлийн индэр болсон билээ.

**И**йнхүү 1997 оны байдлаар Монголд "Ардын эрх", "Засгийн газрын мэдээ", "Өнөөдөр", "Улаанбаатар" зэрэг өдөр тутмын 4 сонин гарч байсны дийлэнх буюу гурав нь төр засгийн харьяалалд ажиллаж байв. Хэдийгээр 1990-ээд оны эхээр "Ардын эрх" сонины захиалга 50000-аас хол давж, мэдээллийн үнэн бодит байдал, сэтгүүлчдийн бичлэгийн ур чадвар, нийгмийн амьдралын олон талыг тусгасан нийтлэлийн бодлогоороо уншигчдаас өндөр үнэлгээ авч байсан ч төр

Засгийн харьялалд байснаараа Америкийн сенатч Ален Кринстоны хэлсэнчлэн "Бие даасан, Засгийн газрын бус, эдийн засгийн хувьд бүрэн бие даасан, олон ургальч үзлийн индэр бөгөөд нийгэмд сөрөг хүчний үүргийг гүйцэтгэж чадахуйц" чөлөөт хэвлэлийг төлөвшүүлэх боломжгүй байсан билээ.

Улсын Их хурал 1998 онд Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль баталснаар "Ардын эрх", "Засгийн газрын мэдээ" сонинууд татан буугдаж 1999 оноос эдгээр сонины бааз сууринд түшиглэн "Өдрийн сонин", "Зууны мэдээ" сонинууд үүсэн бий болсон нь одоо ч манай сонины зах зээл дээр байр сууриа алдалгүй ажилласаар байна. 1998-2004 оныг хүртэл өдөр тутмын "Өдрийн сонин", "Өнөөдөр", "Зууны мэдээ", "Үнэн", "Монголын мэдээ", "Улаанбаатар таймс" зэрэг 6 сонин тогтмол гарч тоо нь нэлээд тогтвортой байснаа 2005-2006 онд ганцхан жилийн дотор 40 хувь буюу дөрвөөр нэмэгдэж шинээр "Ардын эрх", "Өнөөдрийн Монгол", "Нийгмийн толь", "Өглөөний сонин" гарч эхэлснээрээ онцлог юм. Шинээр гарсан сонинуудаас "Ардын эрх" нийгмийн асуудлуудыг онолын түвшинд дэвшүүлсэн, мэргэжилтнүүд, нийтлэлчдийн дорвитой нийтлэлүүдийг нийтэлж, хэлэлцүүлэг

өрнүүлж байгаагаараа, "Өглөөний сонин" шуугиант мэдээлэл, чөлөөт бичлэгээрээ ялгарч байхад нийт өдөр тутмын сонинуудын хувьд дизайн, чимэглэл, макет, нүүрүүдийн хуваарилалт, бичлэгийн өнгө аясаараа хоорондоо төдийлөн ялгарахааргүй нэгэн хэв маяг бүрдүүлсэн нь ажиглагдаж байна.

Монголын сонины зах зээл дэх өдөр тутмын сонины байр суурийг авч үзвэл 1996 оноос хойш захиалга,

борлуулалтын тоогоо ямагт алдсаар 2004 оноос тогтвортой байдалд шилжсэн дүр зураг харагдаж байна. Тухайлбал: Монголын Хэвлэлийн хүрээлэнгийн мониторингийн судалгаагаар 1999 онд нийт өдөр тутмын сонины сүүлийн улирлын захиалгын тоо 41160, 2000 онд 36465, 2001

онд 35200, 2002 онд 34129 болж буурчээ. Энэ хэрээрээ өдөр тутмын сонинууд нийт сонины зах зээлийн борлуулалтанд эзлэх хувь нь буурч, 1999 онд 65 % байснаа 2000 онд 61%, 2001 онд 51%, 2002-2003 онд 47% болтол буурсан байна.

Хамгийн сүүлийн мониторингийн судалгааны дүнгээр Монголын сонины зах зээл дэх өдөр тутмын сонины борлуулалтын тасралтгүй бууралт тогтворжиж, 2005 оны байдлаар 49682-д

«

*Улсын Их хурал 1998 онд Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль баталснаар "Ардын эрх", "Засгийн газрын мэдээ" сонинууд татан буугдаж 1999 оноос эдгээр сонины бааз сууринд түшиглэн "Өдрийн сонин", "Зууны мэдээ" сонинууд үүсэн бий болсон нь одоо ч манай сонины зах зээл дээр байр сууриа алдалгүй ажилласаар байна.*

»

хүрч цаашид өсөх хандлагатай байгаа нь уншигчдын сонголт өдөр тутмын сонин руу чиглэх хандлага байгааг илтгэж байна. Өдөр тутмын сониныг 7, 10 хоног тутмын сонинтой харьцуулахад захиалагчдадаа өндөр урамшуулал амладаггүй, захиалагч бүрд бэлэг тараадаггүй ч шуурхай, тогтмол, харьцангуй мэргэжлийн түвшинд бэлтгэсэн мэдээллээр уншигчдыг хангах бодлого баримталдаг нь нийт сонины зах зээл дэх борлуулалтаа тогтворжуулан улмаар өсөхөд нөлөөлж байгаа нь дамжиггүй. Гэвч өнөөдрийн өдөр тутмын сонинуудын сэтгүүлчдийн бичлэгийн ур чадвар суларсан, нэгэн хэвийн модон найруулгатай, мэдээлэл хоорондоо ихэвчлэн давхардаг, өнгө үзэмж дизайн, сонины нүүрүүдийн хуваарилалт бүтэц зэргээрээ бие биеэсээ төдийлөн ялгаралгүй байгаа, зарим нэгэн нам хүчний талыг нийтлэлийн бодлогодоо хэт барих зэрэг нийтлэг дутагдал нь цаашид сонины зах зээлд өрсөлдөх чадварт нь сөргөөр нөлөөлөх магадлалтай юм.

ОНМХ-ийн үүргийг нэгтгэн базвал мэдээлэх, танин мэдүүлэх (соён гэгээрүүлэх), удирдлагын хэрэгсэл бологч (олон нийтийн санаа бодлыг төлөвшүүлэх), харилцааны болон зугаацуулах зэрэг үндсэн үүргийг гүйцэтгэж байна гэж судлаачид үздэг. Өдөр тутмын нийт сонины нийтлэлийн бодлогод ажиглалт хийхэд нийгмийн өмнө хүлээсэн дээрх үүргээ тодорхой хэмжээнд гүйцэтгэсээр байгаа нь харагдаж байна. Тухайлбал нийтлэгдэж буй мэдээ мэдээллийн 22-28

%-ийг улс төр, 12-15%-ийг урлаг соёл, эдийн засаг санхүү бизнес 8-9.5%, гэмт хэрэг 6-7.6%, олон улсын мэдээ 19.5-20.1%, спорт 4-6.9%, түүх уламжлал 2.7-3%, шинжлэх ухаан танин мэдэхүй, ёс суртахуун, эрүүл мэнд, гэр бүл, хүйсийн тэгш эрх хүний эрх эрх чөлөө, хуувь ёс, боловсрол, шашны сэдэв 6.5-10%-ийг эзэлж байна.

Гэтэл 7, 10 хоног тутмын томоохон сонины нийтлэлийн бодлогыг авч үзэхэд 45-49%-ийг улс төр, 7-8%-ийг гэмт хэрэг, 5.4-6 %-ийг урлаг соёлын оддын хувийн амьдрал, 4.6%-ийг нийгмийн амьдрал, 21.4-30%-ийг томоохон бизнесмен, спортын одод, алдартнуудын хувийн амьдралын тухай, 10 гаруй хувийг шашин, мухар сүсгийн агуулгатай мэдээлэл эзэлж байгаа нь цэвэр арилжааны зорилгоор зөвхөн намуудын амьдрал, улстөрчид, урлаг, спортын оддын хувийн амьдралыг тойрон эргэлддэг тул нийтлэлийн бодлогоороо өдөр тутмын сонинуудад давамгайлах боломж олгож байна. Түүнчлэн өдөр тутмын нийт сонин дээрх сонинуудтай харьцуулахад бичлэгийн төрөл зүйлээрээ илүү баялаг байж чадаж байгаа нь бас нэг давуу тал юм. Тухайлбал Монголын хэвлэлийн хүрээлэнгийн мониторингийн судалгаагаар нийт өдөр тутмын сонинуудад өгүүлэл 31.9%, ярилцлага 18.4%, хөрөг 1.1%, сурвалжлага 8.8%, мэдээ 36 %, редакцийн өгүүлэл 0.5%, тайлбар өгүүлэл 1.6%, захидал 1.3%-ийг эзэлж байна.

Эцэст нь тэмдэглэхэд Монгол оронд хэвлэлийн эрх чөлөө, чөлөөт ардчилсан сэтгүүл зүй хөгжихөд өөр өөрийн өнгө аясаар төлөвшин хөгсөөр буй өдөр тутмын сонинууд жинтэй хувь нэмэр оруулсаар байгаа билээ.

#### Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Г и д д е н с А. 2006. Социологи. УБ.
2. З у л ь к а ф и л ь М. 2001. Сэтгүүл зүйн онолын үндэс. УБ.
3. З у л ь к а ф и л ь М. 2002. Сэтгүүл зүйн онолын зарим асуудал. УБ.
4. Монголын хэвлэл мэдээллийн мониторинг. 1999-2005 он.
5. Н о р о в с ү р э н Л. 2001. Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм. (Дэд боть.) УБ.

6. "Сэтгүүл зүй" МУИС-ийн эрдэм шинжилгээний бичиг. 2005. №249.

#### Abstract

Mongolian Daily newspapers is forty five years, there was only one daily newspaper for the one political party in government before 1990. Free press started in Mongolia at the same time as the transition to democracy and a free market system. This period was particularly interesting as the number of daily newspapers in print increased, which included government, private and former government papers sold to private organisations. The development of daily newspapers was vital in the development free press and journalism in Mongolia, which began with the end of socialism in 1990.